



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/664

Хэрлэн сум

Шилдэг сум, эцэг эхийн зөвлөлийг
шагнаж урамшуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхэд, хөгжил хамгааллын жил"-ийн хүрээнд баталсан шилдэг сум, эцэг эхийн зөвлөл шалгаруулах удирдамжийн дагуу шаардлага хангасан шилдэг сум, эцэг эхийн зөвлөлийг шагнаж урамшуулах зардалд 6,550,000 (зургаан сая таван зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний "Хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 12 дугаар сарын 02-ны
..... дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Шилдэг сумын шагнал	1	1-р байр - 1,000,000 2-р байр - 800,000 3-р байр - 600,000 4-р байр - 500,000 5-р байр - 300,000	3,200,000
2	Шилдэг эцэг эхийн зөвлөлийн шагнал	1	1-р байр - 800,000 2-р байр - 600,000 3-р байр - 500,000 4-р байр - 400,000 5-р байр - 300,000	2,600,000
	Өргөмжлөл	10	75,000	750,000
		Нийт		6,550,000